

2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024.05.15.

1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт, Говьсүмбэр 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн заалт, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт, Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнөөс өөрийн байгууллагад хамааралтай заалтуудыг хяналтад авч байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан.

Бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын 6.2.1, 6.2.2-д заасан үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийж, 2000 тэмдэгтэд багтаан товч тодорхой тайлагнасан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж хүрэх түвшинг тоон үзүүлэлтээр төлөвлөсөн.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн жилийн төлөвлөгөө, Эдийн засаг нийгмийн хөгжлийн төлөвлөгөө, Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хамтран ажиллах гэрээний биелэлт, Сайдтай байгуулах гэрээний хэрэгжилт, Ил тод нээлттэй байдлын тайлан, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн тайлан, Ногоон байгууламж, мод бут тарих, цахим шилжилт, хог хаягдлын менежмент зэрэг Бодлогын баримт бичгийн тайланг хугацаанд гаргаж, 2024 оны 05 дугаар сарын 16 өдрийн 70 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Номын фондыг төсөв болон хандиваар 148 ширхэг номоор нэмэгдүүлж, электрон каталогт 100 хувь оруулан иргэдэд хүргэсэн. Интернэт орчинд байгууллагын электрон каталогийг байршуулж гар утас, компьютероор гэр ажлын байрнаас орж номоо сонгох боломжийг бүрдүүлэн ажилласан.

Хөдөөгийн багийн 4,5,6-р багаар зөөврөөр шинэ номын танилцуулга хийж, электрон каталогид QR код үүсгэн гарын авлага дээр хэвлэн гаргаж тараан утсаар уншуулан номоо сонгож, өөрийн хэрэгцээт номоороо үйлчлүүлэх, шинэ номын мэдээлэл авах талаар сурталчилсан.

Иргэд уншигчид, байгууллага, анги хамт олны дунд “Ном уншлагын аян” зохион байгуулж уншигчийн тоо болон байгууллагын орлогыг нэмэгдүүлсэн.

Байгууллагын төлөвлөгөөг календарчилан гаргаж хэрэгжилтийн явцад хяналт тавин ажилласан.

Байгууллагын ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр:

Байгууллагын цахим хуудаст Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу ил тод байдал, цахим хуудасны мэдээллийг үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийн бодлогын ил тод байдал, төсөв, санхүүгийн ил тод байдал зэрэг ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тогтмол оруулж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын төсөв, санхүү болон худалдан авах ажиллагаатай холбоотой 35 мэдээ мэдээллийг цахим хуудас, веб сайтад тогтмол шинэчлэн байршуулсан.

Албан хаагчдын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, ёс зүйн байдалд хяналт тавих, ёс зүйн зөрчлийн асуудлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус “Ес зүйн дэд хороо”-ийг Номын захирлын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/05 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна.

Байгууллагын хүний нөөцийн нэгдсэн системийн үйл ажиллагааг ханган Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11-р сарын 14-ны өдрийн 600-р тогтоолын дагуу албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу шинэчилэн мэдээллийг цахим хуудсанд байршуулсан.

Байгууллагын дотоод журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг цахим хуудсанд байршуулсан.

Шилэн дансны хөтлөлтийг сайжруулах чиглэлээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж байна. Өр авлага үүсгээгүй, санхүү, төсвийн хувьд зөрчилгүй. Мэдээ тайланг хугацаанд нь байршуулж байна.

Авилгын эсрэг төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг цахим хуудсанд байршуулах.

Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн видео-3, иргэд, олон нийтэд нийтэлсэн мэдээлэл-3, гарын авлага-5-ыг вэб сайт, Говьсүмбэр Нийтийн Номын Сан цахим хуудсанд байршуулсан

Цахимжуулалтын чиглэлээр: Төрийн үйлчилгээний цахим e-mongolia системийг сурталчлах, шаардлагатай үйлчилгээг e-mongolia системээс авах, иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах зэсийг байгууллагын вэб хуудасанд байршуулж, өргөдөл, гомдол хүлээн авах албан хаагчийн мэдээллийг оруулсан. Байгууллагын үйлчилгээний уншигчийн карт нээх, гэрээр ном олгох үйлчилгээг Emongolia системд нэвтрүүлэхээр бүртгэлээ хийлгэн ажиллаж байна.

Албан бичиг шилжүүлэх, ирсэн явсан бичгийг тогтмол хүлээн авч, ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн явуулах зэрэг албан байгууллагуудтай холбогдон үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж байна. ERP системээр ирсэн бичиг 80, явсан 59, өргөдөл гомдол санал хүсэлт 14-ийг бүртгэж албан хэрэг хөтлөлтийг цахимжуулсан.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь хурдан шуурхай шийдвэрлэх.

Говьсүмбэр Номын Сан цахим хаяг, <http://library.gs.gov.mn/> вэб сайтаар иргэд уншигчдын өргөдөл гомдол санал хүсэлтийг авахаар ажиллаж байна.

Одоогоор ирсэн санал гомдол хүсэлт байхгүй.

Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж, төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285: 2017 стандартын дагуу хөтөлж хэвшин ажиллаж байна.

Тайлан бичсэн: Арга зүйч А.Чимэгмаа